

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛЭГ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Үйлчлүүлэгчид болон эмч, эмнэлгийн ажилчдын сэтгэл ханамжийн судалгааны дүн, тайлан

2018 оны 12 дугаар сарын 12



Улаанбаатар хот


2018 оны жилийн эцсийн байдлаар 4893 үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авсан ба энэ нь нийт хэвтэн эмчлүүлэгчдийн 55 хувийг хамарч байна. Эерэг сэтгэл ханамж 92,6%-тай байна. 2018 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 227 эмч, эмнэлгийн ажилчдаас нийт 4 удаа сэтгэл ханамжийн судалгаа авсан.

Сэтгэл ханамжийн судалгаанд нийт ажиллагсдын 94% нь хамрагдсан. Эерэг сэтгэл ханамж – 80 % байна.


Чанарын албанаас авсан ажлын хандлагын судалгаанд 64 эмч, эмнэлгийн ажилтан буюу нийт ажилчдын 55 % нь оролцсон. Ерөнхий сэтгэл ханамж-3.63 оноотой 72,6 %-ийн үнэлгээ авсан байна.

Ажилчдаас ёсзүйн сэтгэл ханамжийн судалгааг 4удаа, давхардсан тоогоор 23 асуумжаар авсан бөгөөд судалгаанд давхардсан тоогоор нийт 227 ажилтан хамрагдаж эерэг сэтгэл ханамжийн хувь 81 %, ёс зүйн сэтгэл ханамжийн судалгааг үйлчлүүлэгчдээс 5удаа, давхардсан тоогоор нийт 25 асуумжаар авч 250 үйлчлүүлэгч хамрагдаж эерэг сэтгэл ханамжийн хувь 74,2 % байна.







2018 оны 04-р сард эмч, эмнэлгийн ажилтдаас авсан ажлын хандлагын судалгааны дүн




2018 оны 05-р сард эмч, эмнэлгийн ажилчдын ёс зүй, харьцаа хандлагын талаар үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн



2018 оны 03-р сард эмч нарын үзлэг болон харилцаа, ур чадварын талаар үйлчлүүлэгчдээс авсан сэтгэл ханамжийн судалгааны дүн



Эмч, эмнэлгийн ажилчдаас авсан сэтгэл ханамжийн судалгааны харьцуулалт /2018 оны 01-р сар, 10-р сар/



Үйлчлүүлэгчийн тавьсан саналыг нэгтгэхэд:

1. Яаралтай тусламжийн тасагт эмч нэмэгдүүлэх
2. Эмчилгээний тасагт сувилагчийн орон тоог нэмэгдүүлэх
3. Гадна орчны тохижилтыг сайжруулах
4. Автомашин зогсоолыг өргөтгөх, тэмдэгжүүлэх
5. Камерыг олшруулах, сайжруулах
6. Бие засах суултуурын тоог нэмэгдүүлэх
7. Нэмэлт тасаг нээх

Үйлчлүүлэгчийн саналыг тусган хэрэгжүүлсэн ажил:

1. Яаралтай тусламжийн тасагт ачаалал ихэссэн үе болон амралтын өдрүүдээр нэмэлтээр 1-2 эмчийг ажиллуулж байна.
2. Эмчилгээний тасагт 2 жигүүрийн дунд 1 сувилагчийг процедур сувилагчаар 24 цагаар нэмэн ажиллуулж байна.
3. 9 туслах сувилагч бэлтгэснээс 3 туслах сувилагчийг орон тоогоор нь ажиллуулж эхэлсэн

4. Дүүргийн жишиг эмнэлгийн барилгын ажил эхэлсэнтэй холбоотой гадна орчин болон автомашины зогсоолын асуудал шийдвэрлэх боломж муу болсон
5. Яаралтай тусламжийн тасагт ЭМТөвийн 1 эмчийг ажлын өдрөөр 17-22 цагийн хооронд ажиллуулж байна.
6. Яаралтай тусламжийн тасгийн хүлээлгийн өрөөнд халаалт тавьж өрөөний тоог нэгээр нэмэгдүүлсэн.
7. Яаралтай тусламжийн үзлэгийн өрөөг шинээр нэмэгдүүлсэн ба амралтын өдрөөр 24 цагаар ажлын өдрөөр 5 цагаар нэмэлт эмч ажиллуулж байна.
8. Томуу томуу төст өвчний дэгдэлтийн улирлыг угтуулан 40 ортой нэмэлт тасаг нээж ажиллуулсан
9. Мөн тэтгэврийн эмч -1, асрагч – 2, нөөцөнд бүртгэгдсэн асрагч – 1, сувилагч – 1 нарыг дайчлан ажиллуулж байна.



10. Шинээр 16 камер худалдан авч, тасаг нэгжүүдэд суурилуулан хэвтэн эмчлүүлэгчдийн өмч хөрөнгийн аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж байна.



11. Эмнэлгийн дотоод агаарыг цэвэршүүлэх БНСУлсын HAATS брендийн 66 000 000 төгрөгний 13 ширхэг агаар цэвэршүүлэгч, 40 ширхэг өрөөний агаар цэвэршүүлэгч тусламж үйлчилгээндээ ашиглаж байна.



Үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэх чиглэлээр шинээр санаачлан хийсэн үйл ажиллагаа

- Эмнэлгийн 1 давхрын үүдний 38м2 бистульд 5 сая төгрөгийн өртөг бүхий засвар үйлчилгээ хийв. Үүнд: Вестублийн таазыг уналттай тааз болгож өөрчлөн нүдэн гэрэлүүд суулган, шинээр явган хана хийж, ханыг дотор сайддингаар өнгөлж, хулсан хөшиг тавьсан.

Өмнө нь:



- Хүүхдийн 2 тасагт ажилчдын душны өрөөний хуучин плитаг хуулан шинэ плита нааж өнгөлөн цорго шүршүүрийг тогтоон сантехникийн холболт угсралтыг хийв. Душ холигч 88 мян.төг.
- Эмнэлгийн 1-р давхарт нийт 36 м2 паркетан шал солив. Нийт өртөг 737 мян төгрөг.
- Хүүхдийн 2-р тасагийн бокс хоорондын хаалт болон хаалганы шил байхгүй дараах палатнуудын шилийг шиллэж өгөв. “Өнгөт цацал ХХК. Нийт өртөг 112640₮.
 - Баруун жигүүрийн №2,3,4-р палатуудын хаалганы шил 2ш, өрөө хоорондын хаалт шил 6 ш, коридорын хаалганы шил 1ш
 - Зүүн жигүүрийн №5 палатны хаалганы болон өрөө хоорондын хаалт шил тус бүр 1ш

- Эмнэлгийн 3 давхрын шатны хажуугийн хэсэгт хүүхэд унаж бэртэхээс хамгаалсан хаалт хийв.

Шатны хаалт: Өмнө нь:

Дараа нь:



- Шинээр 16 камер худалдан авч, тасаг нэгжүүдэд суурилуулан хэвтэн эмчлүүлэгчдийн өмч хөрөнгийн аюулгүй байдалд хяналт тавин ажиллаж байна.



- Эмнэлгийн дотоод агаарыг цэвэршүүлэх БНСУлсын HAATS брендийн 66 000 000 төгрөгний 13 ширхэг агаар цэвэршүүлэгч, 40 ширхэг өрөөний агаар цэвэршүүлэгч тусламж үйлчилгээндээ ашиглаж байна.



- Эрчимт эмчилгээ яаралтай тусламжийн тасгийн үзлэгийн өрөөг шинээр нэмэгдүүлэхээр “Нобел” Эм Ханган Нийлүүлэх компанийн буцалтгүй тусламжаар 1,280,000 төгрөгний үнэ бүхий шинээр хаалга суурилуулж эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчлүүлэгчдийн тохь тухыг хангасан..



- Гадаад орчны тохижилтонд тоосжилтыг бууруулахаар 150,000 төгрөгний үнэ бүхий хайргаар үйлчлүүлэгчдийн явах замыг хучиж тэгшилсэн.



- Эмнэлгийн гаднах хацааг сэргээн будаж гадна орчны өнгө үзэмжийг нэмсэн.

